

*САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
2020 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
.... дугаар тогтоолын Хавсралт*

**КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ**

/Компанийн бонд/

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Энэ журмаар компанийн өрийн хэрэгсэл /цаашид “бонд” гэх/-ийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах, нийтэд санал болгон гаргах бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны зөвшөөрөл олгох, бонд гаргагч, зохицуулалттай этгээд, Хорооны чиг үүрэг болон бонд гаргагчийн мэдээллийн ил тод байдалтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Засгийн газрын үнэт цаас, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон энэ журмын 3.2-т зааснаас бусад Биржийн бус зах зээлд буюу мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгох бондыг бүртгэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.
- 1.3 Нээлттэй хувьцаат компанийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондыг бүртгэхтэй холбоотой нийтлэг харилцааг Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмаар, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны зөвшөөрөл, бонд гаргагчийн мэдээллийн ил тод байдал, хувьцаанд хөрвөсөн бондыг бүртгэлээс хасажтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.4 Хаалттай хувьцаат компанийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй нийтэд санал болгох бондын бүртгэлийг энэ журмаар зохицуулна.

**ХОЁР. БОНД ГАРГАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 2.1. Бонд гаргагч нь компанийн хэлбэрээсээ үл хамааран нийтэд санал болгон бонд гаргаж болно.
- 2.2. Энэ журмын 3.1-т заасан бонд гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна.
  - 2.2.1. Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд байх;
  - 2.2.2. Хороонд хүсэлт гаргах үед үүсгэн байгуулагдаад гурван жил болсон, сүүлийн хоёр жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
  - 2.2.3. Хороонд хүсэлт гаргах үед зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;
  - 2.2.4. бондын үнийн дүнгээс багагүй өөрийн хөрөнгөтэй байх;
  - 2.2.5. энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй нийтэд санал болгох бонд гаргагч нь хувьцаат компани хэлбэртэй байх;

- 2.3. Бонд гаргагч нь бондоо нийтэд санал болгох бол Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий андеррайтерийн компанитай гэрээ байгуулсан байна.
- 2.4. Хороонд бүртгүүлэх нийтэд санал болгох бонд нь арилжаа эрхлэх байгууллагын, энэ журмын 3.2-т заасан хаалттай хүрээнд санал болгох бонд нь биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд тус тус бүртгүүлсэн байна.
- 2.5. Бонд гаргагч нь бондын үүргийн гүйцэтгэлийг хангах өөрийн, эсхүл өөр этгээдээс тусгайлан гаргасан барьцаатай байж болох бөгөөд энэхүү барьцаа нь бонд гаргагч компанийн гаргасан, зарласан эсхүл хөрвөх нөхцөлтэй үнэт цааснаас бусад төрлийн хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэртэй байна.
- 2.6. Бонд гаргагч нь нээлттэй хувьцаат компани бол энэ журмын 2.2.2 дахь заалт хамаарахгүй.
- 2.7. Бонд гаргагч нь батлан даагчтай бол бонд гаргагч болон түүний батлан даагчийн өөрийн хөрөнгийн нийлбэр дүн нь энэ журмын 2.2.4-д заасан хэмжээнээс багагүй байна.
- 2.8. Хороо энэ журмын 2.2.2, 2.2.4-д заасан шаардлагыг бондын танилцуулгад заасан аудитын тайлангаар баталгаажсан санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын тайлангаар баталгаажуулна.
- 2.9. Хаалттай хувьцаат компани нь энэ журмын 2.2.5-д заасан бондыг гаргахад түүний хөрвөх энгийн хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгүүлсэн байна.
- 2.10. Бонд гаргагч энэ журмын 2.2-т заасан шаардлагыг хангаагүй нь түүний хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.

### **ГУРАВ. ХОРООНЫ БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮСЭЛТИЙГ ХЯНАХ, БОНДЫГ БҮРТГЭХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ**

- 3.1. Бонд гаргагч нь нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бондыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ.
  - 3.1.1. албан хүсэлт;
  - 3.1.2. бондыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 1-д заасан Маягт – СЗХ\*\*\*\*\*-ын дагуу/;
  - 3.1.3. арилжаа эрхлэх байгууллагын “Бүртгэв” тэмдэглэл бүхий бондын танилцуулга /2 эх хувь/;
  - 3.1.4. бонд гаргагчийн бонд гаргахтай холбоотой болон гуравдагч этгээд баталгаа гаргасан бол түүний баталгаа гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;
  - 3.1.5. бонд нь хаалттай хувьцаат компанийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бол түүний хөрвүүлэх хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт;
  - 3.1.6. андеррайтерийн компанитай байгуулсан гэрээ, тодорхойлох захидал;
  - 3.1.7. Хороонд хүсэлт гаргахаас өмнөх 6 сарын доторх хугацааны санхүүгийн тайланд гаргасан аудиторийн тодорхойлох захидал;
  - 3.1.8. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт.
- 3.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.3, 9.4-т тус тус заасан нийтэд санал болгон гаргасан үнэт цаас нь Хороонд бүртгэлтэй байгаа этгээд биржийн бус зах зээлд шинээр эсхүл нэмж гаргах хаалттай бондыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ.

- 3.2.1. албан хүсэлт;
- 3.2.2. бондыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 2-д заасан Маягт – СЗХ\*\*\*\*\*-ын дагуу/;
- 3.2.3. бонд гаргагчийн хаалттай хүрээнд бонд гаргахтай холбоотой болон гуравдагч этгээд баталгаа гаргасан бол тухайн баталгаатай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;
- 3.2.4. биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;
- 3.2.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.
- 3.3. Монгол Улсад бүртгэгдсэн гадаад улсын хөрөнгийн биржид бонд бүртгүүлэх этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.3-т заасны дагуу дараах баримт бичгийг Хороонд хүргүүлж, мэдэгдэнэ.
  - 3.3.1. албан бичиг;
  - 3.3.2. Мэдэгдэл /Хавсралт 3-д заасан Маягт \*\*\*\*\*-ын дагуу/;
  - 3.3.3. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.
- 3.4. Бонд гаргагч энэ журамд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлж, Хороонд хэвлэмэл хэлбэрээр хүргүүлэх бөгөөд цахим хэлбэрээр нэмэлтээр хүргүүлж болно.
- 3.5. Хороо арилжаа эрхлэх байгууллага болон биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд тус тус бүртгүүлсэн энэ журмын 3.1-д заасан нийтэд санал болгох бондыг, 3.2-т заасан хаалттай бондыг тус тус Хорооны бүртгэлд бүртгэнэ.
- 3.6. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Хороо бонд гаргагчийн ямар нэгэн нөхцөл болзолтойгоор бондыг бүртгэхгүй.
- 3.7. Энэ журмын 3.2-т заасан этгээд нь компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн ил тод байдлыг хангаагүй, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллагаагүй нь тухайн бондыг бүртгэхээс татгалзах үндэслэл болно.
- 3.8. Энэ журмын 3.1-т заасан этгээд нь нээлттэй хувьцаат компани хэлбэртэй бол тус этгээдэд журмын 3.7 дахь заалт нэгэн адил хамаарна.
- 3.9. Бонд гаргагчийн хүргүүлсэн баримт бичиг нь агуулгын хувьд зөрүүтэй, тодорхойгүй тохиолдолд Хороо тайлбар, тодруулгыг нэмэлтээр ирүүлэхийг бонд гаргагчид мэдэгдэж болно.
- 3.10. Хорооны Ажлын алба Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжид заасан болон энэ журамд заасан бүртгэхээс татгалзах үндэслэлтэй гэж үзвэл бондыг бүртгэхээс татгалзаж, бонд гаргагчид энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ.
- 3.11. Хороо энэ журмын 3.1, 3.2-т заасан баримт бичгийн бүрдэл, агуулгыг хянаж, холбогдох хууль, тогтоомж болон энэ журамд заасан бүртгэхээс татгалзах үндэслэлгүй бол журмын 3.1-д заасан бонд, түүний танилцуулгыг арилжаа эрхлэх байгууллагад бүртгэсэн тухай дүгнэлтийг, 3.2-т заасан бондыг биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг тус тус үндэслэн бүрдэл нь бүрэн баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэнэ.
- 3.12. Энэ журмын 5.1.5-д заасан хэлбэрээр нийтэд санал болгох бондын нийлүүлэлтийг журмын 4.1-д заасан хугацаа дууссанаас хойш хийх бол бонд гаргагч этгээдийн хөрөнгө оруулалтын зарцуулалт, мөнгөн урсгалын төсөөлөл, шаардлагатай бусад мэдээллийг бондын танилцуулгад шинэчлэн тусгаж, уг хугацаа дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлнэ.

- 3.13. Хороо энэ журмын 3.12-д заасан бондын танилцуулгын нэмэлт, өөрчлөлтийг арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрийг үндэслэн ажлын таван өдрийн дотор Хорооны даргын тушаалаар бүртгэнэ.
- 3.14. Нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн бондын танилцуулга тус бүрд Хорооны “Бүртгэв” тэмдэглэл хийж, бонд гаргагч, андеррайтер болон арилжаа эрхлэх байгууллага тус бүрд нэг хувийг хүргүүлж, нэг хувийг Хороонд хадгална.
- 3.15. Хороо бондыг бүртгэсэн тухай шийдвэрийг бонд гаргагч, арилжаа эрхлэх байгууллага эсхүл биржийн бус зах зээлийн байгууллага болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.
- 3.16. Хорооны Ажлын алба энэ журмын 3.3-т заасан мэдэгдлийг хүлээн авсан тухай Хорооны мэдэгдэл /Хавсралт 3-д\*\*\*-д заасан Маягт \*\*\*\*/-ийг ажлын гурван өдрийн дотор тухайн үнэт цаас гаргагчид хүргүүлнэ.
- 3.17. Энэ журмын 3.3-т заасан этгээд нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн тохиолдолд тухайн байгууллагын шийдвэрийн хувийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдөрт багтаан Хороонд хүргүүлнэ.
- 3.18. Хорооны бүртгэлээс бондыг хасахад бонд гаргагч нь зохих төлбөрийг бүрэн төлж, арилжаа эрхлэх байгууллага, эсхүл биржийн бус зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс бондыг хасуулсан, эсхүл хуульд заасан бусад тохиолдол буюу бонд гаргагчийг татан буулгах ажиллагаа бүрэн хэрэгжиж дууссан тохиолдолд холбогдох этгээдийн дүгнэлт, мэдэгдлийг үндэслэнэ.
- 3.19. Энэ журмын 3.1-д заасан бондыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасуулахад бонд гаргагч дараах баримт бичгийг Хороонд хүргүүлнэ.
- 3.19.1. албан хүсэлт;
- 3.19.2. хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн тухай андеррайтерийн мэдэгдэл;
- 3.19.3. бондыг хувьцаат компанийн хувьцаанд хөрвүүлсэн бол уг үйл ажиллагаа нь хууль, журмын дагуу явагдсан тухай андеррайтерийн мэдэгдэл;
- 3.19.4. бондыг хувьцаат компанийн хувьцаанд хөрвүүлсэн үнэт цаас эзэмшигчийн өмчлөх эрх баталгаажсан тухай төвлөрсөн хадгаламжийн байгууллагын мэдэгдэл;
- 3.19.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.
- 3.20. Энэ журмын 3.2-т заасан этгээд Хорооны бүртгэлийн үндсэнд биржийн бус зах зээлд гаргасан бондыг бүртгэлээс хасуулахад дараах баримт бичгийг Хороонд хүргүүлнэ.
- 3.20.1. албан хүсэлт;
- 3.20.2. хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн тухай компанийн мэдэгдэл;
- 3.20.3. биржийн бус зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс тухайн бондыг хассан тухай шийдвэр;
- 3.20.4. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.
- 3.21. Хорооны Ажлын алба энэ журмын 3.19, 3.20-д заасан баримт бичгийн бүрдэл, агуулгыг хянаж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн тохиолдолд ажлын 10 өдрийн дотор Хорооны хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

- 3.22. Хорооны Ажлын албан бондыг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг бонд гаргагч, арилжаа эрхлэх болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан ажлын гурван өдрийн дотор олон нийтэд мэдээлнэ.
- 3.23. Хороо энэ журмын дагуу бүртгэсэн болон бүртгэлээс хассан тухай бондын нэгдсэн мэдээллийг Хавсралт 10-д заасан маягтын дагуу хөтөлнө.

#### **ДӨРӨВ. АНХДАГЧ БОЛОН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА**

- 4.1. Энэ журмын 3.1-т заасан бондыг андеррайтер нь Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сарын дотор анхдагч зах зээлд санал болгож, захиалга авах үйл ажиллагааг гүйцэтгэж дууссан байна.
- 4.2. Андеррайтер нь стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн захиалгын дагуу бондыг анхдагч зах зээлд санал болгох, түүнтэй бондыг худалдах асуудлаар урьдчилан хэлэлцээр хийснийг нийтэд санал болгосонд тооцохгүй.
- 4.3. Андеррайтер нь бондыг нийтэд танилцуулах ажиллагааг зохион байгуулж, бондын танилцуулгад тусгасан нийтэд арилжих журамд заасан арга хэлбэрээр санал болгох бөгөөд анхдагч зах зээлийн захиалгыг Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэнд эхлүүлнэ.
- 4.4. Андеррайтер нь бондын арилжааны анхдагч зах зээлийн захиалгыг эхлүүлэх хүсэлт /Хавсралт 4-д заасан Маягт \*\*\*\*-ын дагуу/-ийг уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө Хороонд гаргана.
- 4.5. Бондын арилжааны анхдагч зах зээлийн захиалгын зөвшөөрлийг олгох эсэх асуудлыг Хорооны дарга ажлын гурван өдрийн дотор шийдвэрлэнэ.
- 4.6. Андеррайтер нь анхдагч зах зээлд арилжих бондын захиалга авах үйл ажиллагааг ажлын таван өдрийн дотор хийж гүйцэтгэнэ.
- 4.7. Энэ журмын 5.1.5-д заасан хэлбэрээр бондыг нийтэд санал болгоход анхдагч зах зээлд хийх нийлүүлэлт тус бүрд энэ журмын 4.4 болон 4.6-т заасан хугацаа нэгэн адил хамаарна.
- 4.8. Бонд гаргагч нь энэ журмын 5.1.3-т заасны дагуу варрант гаргасан бол варрант эзэмшигч нь энэ журмын 4.6-д заасан хугацаа дуусахаас өмнө бондын зохих төлбөрийг гүйцэтгэнэ.
- 4.9. Андеррайтер бондын арилжааны анхдагч зах зээлийн захиалгыг авч дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор хуваарилалтыг хийн, тайлан /Хавсралт 5-д заасан Маягт\*\*\*\*-ын дагуу/-г арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлтийн хамт Хороонд хүргүүлнэ.
- 4.10. Хорооны ажлын алба анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон тухай мэдэгдлийг андеррайтерт хүргүүлэх хүртэлх хугацаанд татан төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийг банкин дахь бонд гаргагчийн тусгайлсан дансанд байршуулна.
- 4.11. Андеррайтер нь захиалгын бүртгэлийн аргаар бондын захиалгыг бүрдүүлэх тохиолдолд бондын танилцуулгад тусгасан хүүгийн дээд, доод хязгаарын хүрээнд захиалгыг хүлээн авч, ирүүлсэн үнийн саналд үндэслэн хүүг бонд гаргагчийн саналыг харгалзан тогтооно.
- 4.12. Анхдагч зах зээлийн арилжааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсэгт заасан нөхцөлд амжилттай явагдсанд тооцно.
- 4.13. Хорооны Ажлын алба энэ журмын 4.9-т заасан тайланг хүлээн авч анхдагч зах зээлд бондыг амжилттай байршуулж, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл олон нийтэд мэдээлж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэлийг баталгаажуулах мэдэгдлийг, арилжаа эрхлэх байгууллагад бондын хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг ажлын гурван өдрийн дотор тус тус хүргүүлнэ.

- 4.14. Хороонд бүртгүүлсэн бондыг энэ журмын 4.1-д заасан хугацаанд бондын танилцуулгад заасан хэмжээгээр анхдагч зах зээлд байршуулаагүй, эсхүл 4.12-д заасан нөхцөл бүрдээгүй тохиолдолд анхдагч зах зээлийн захиалгыг цуцлах мэдэгдлийг андеррайтерт хүргүүлж, бондын бүртгэлийг ажлын арван өдрийн дотор Хорооны хуралдаанаар хүчингүй болгоно.

## **ТАВ. БОНД ГАРГАГЧ, ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭД, ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ**

- 5.1. Бонд гаргагч дараах чиг үүрэгтэй.
- 5.1.1. Бонд гаргагч нь андеррайтераас гаргасан нарийвчилсан шинжилгээ, судалгаа, хийсэн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн нийтэд санал болгох бондын үнэ, хүүний түвшинг тогтооно.
- 5.1.2. Бонд гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн бондыг Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргах эрхтэй бөгөөд уг хүсэлт нь хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх явцын мэдээ, мэдээллээр хангагдах эрхтэй.
- 5.1.3. Бонд гаргагч нь нийтэд санал болгон гаргах бондыг тодорхой үнэ, хувь хэмжээгээр худалдан авах эрхийг гэрчлэх варрант гаргаж болно.
- 5.1.4. Бонд гаргагч санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох эрх бүхий байгууллагаар зэрэглэл тогтоолгож болно.
- 5.1.5. Бонд гаргагч нь нэг удаа бүртгүүлсэн бондын нийлүүлэлтийг хэд хэдэн үе шаттай буюу траншаар хийж болох бөгөөд энэ тухай бондыг танилцуулгад тодорхой тусгаж, нийт нийлүүлэлтийг Хороонд бүртгүүснээс хойш нэг жилийн дотор хийсэн байна.
- 5.1.6. Энэ журмын 5.1.5-д заасан хэлбэрээр бондыг нийтэд санал болгоход анхны нийлүүлэлтийг энэ журмын 4.1-д заасан хугацаанд хийнэ.
- 5.1.7. Нийт бүртгэлтэй бондын нийлүүлэлтийн багц тус бүрийн нөхцөл харилцан адилгүй байж болох бөгөөд энэ тухай ерөнхий мэдээллийг бондын танилцуулгад тусгасан байна.
- 5.1.8. Бонд гаргагч энэ журмын 3.1-д заасан бондыг журмын 4.1-д заасан хугацаа дууссанаас хойш нийтэд санал болгох тохиолдолд бондын танилцуулгыг шинэчлэн Хороонд бүртгүүлнэ.
- 5.1.9. Энэ журмын 5.1.8-д заасны дагуу бондын танилцуулгыг шинэчлэн бүртгүүлэхэд журмын 4.1-д заасан хугацаа дуусахаас ажлын 10 өдрөөс доошгүй хугацааны өмнө арилжаа эрхлэх байгууллагад хүсэлт гаргаж, Хороонд мэдэгдэл хүргүүлнэ.
- 5.1.10. Нийтэд санал болгон гаргасан бондыг хугацаанаас нь өмнө бүхэлд нь эсхүл хэсэгчлэн эргүүлэн худалдан авах, шаардлагатай тохиолдолд худалдаж болно.
- 5.1.11. Бонд гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагын энэ журмын 5.4.12-т заасан хүсэлт, аливаа шаардлага нь үндэслэлгүй, эсхүл бүртгэхээс татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд гомдол гаргах эрхтэй.
- 5.1.12. Хороо бондыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд бонд гаргагч уг шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Хорооны Хяналтын зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

- 5.1.13. Хорооноос бондын бүртгэлтэй холбоотой аливаа мэдээлэл хүргүүлэхийг шаардсан бол тодруулга, нэмэлт баримт бичгийг бонд гаргагч нь заасан хугацаанд Хороонд хүргүүлэх үүрэгтэй.
  - 5.1.14. Бонд гаргагч нь Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллах үүрэгтэй.
  - 5.1.15. Тухайн гаргасан бондын үүргийн гүйцэтгэлийн баталгаа нь үл хөдлөх хөрөнгө бол барьцаа хөрөнгийг эд хөрөнгийн бүртгэлийн төрийн эрх бүхий байгууллагад андеррайтерийн нэр дээр барьцаалбарт бүртгүүлнэ.
  - 5.1.16. Бонд гаргагч нь холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.
  - 5.1.17. Бонд гаргагч нь тухайн гаргасан бондыг бүртгүүлэхтэй холбоотойгоор арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд хүргүүлсэн үнэт цаасны танилцуулга, түүнд хавсаргасан холбогдох баримт бичиг, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт зэрэг болон бусад баримт бичгийг бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд компани дээрээ хадгалах үүрэгтэй.
  - 5.1.18. Бонд гаргагч нь андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байх шаардлагатай бөгөөд талууд сонирхлын зөрчилгүй этгээд байна.
- 5.2. Зэрэглэл тогтоох байгууллага дараах чиг үүрэгтэй.
    - 5.2.1. хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай бонд гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг бонд гаргагчаас гаргуулан авсан байна.
    - 5.2.2. бонд гаргагчийн санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд Хорооноос тогтоосон Ёс зүйн дүрмийг мөрдөх үүрэгтэй;
    - 5.2.3. Зэрэглэл тогтоох байгууллага нь тухайн бонд гаргагчийн Зэрэглэлийг хагас жил болон жилийн санхүүгийн тайланд үндэслэн тухай бүрд шинэчлэн тогтоох үүрэгтэй.
- 5.3. Андеррайтер дараах чиг үүрэгтэй.
    - 5.3.1. Андеррайтер нь хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай бонд гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг бонд гаргагчаас гаргуулан авсан байна.
    - 5.3.2. Андеррайтер нь бондын танилцуулгыг бэлтгэж, анхдагч зах зээлийн захиалгыг авах, хуваарилах болон байршуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
    - 5.3.3. Андеррайтер нь бондыг анхдагч зах зээлд тодорхой хэмжээгээр багцлан стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгох, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн худалдан авч болно.
    - 5.3.4. Хоёр болон түүнээс дээш тооны андеррайтер хамтран синдикат хэлбэрээр ажиллах тохиолдолд тэргүүлэх болон туслах андеррайтерийн чиг үүрэг, хариуцлагыг оролцогч талуудын хооронд байгуулсан гэрээнд тодорхой тусгасан байна.
    - 5.3.5. Андеррайтер нийтэд санал болгон гаргах бондын анхдагч зах зээлийн арилжааг бондын танилцуулгад тусгасны дагуу дараах үе шаттайгаар зохион байгуулна.
      - 5.3.5.1. захиалга авах;

- 5.3.5.2. танилцуулгад тусгасан бол авсан захиалгын үндсэнд үнэ тогтоох;
  - 5.3.5.3. захиалгын хуваарилалтыг хийх.
  - 5.3.6. Андеррайтер нь анхдагч зах зээлд бондын хуваарилалтыг хийхдээ ижил нөхцөлтэй захиалга бүхий хөрөнгө оруулагчийн захиалгын хуваарилалтыг түүний брокероос үл хамааран ахлах дарааллын хувьд тэгш зарчмаар хийж, байршуулна.
  - 5.3.7. Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондын анхдагч зах зээлийн хуваарилалтыг хийхэд тухайн бонд гаргагч компанийн хувьцаа эзэмшигчийн захиалгын түүний эзэмшиж байгаа хувьцааны тоонд хувь тэнцэх хэсгийг тэргүүн ээлжид хуваарилах бөгөөд илүү гарсан захиалгыг ахлах дарааллын хувьд тэгш зарчмаар хийж байршуулна.
  - 5.3.8. Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжааны захиалга авах явцад харилцагчийг таньж мэдэх, аливаа сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.
  - 5.3.9. Андеррайтер болон бонд гаргагч нь Хороонд бүртгүүлсэн бондын танилцуулгыг нийтэд үнэ төлбөргүй хүргэх бөгөөд сонирхсон бүх этгээдийг танилцах боломжоор хангана.
  - 5.3.10. Андеррайтер мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой мэдээ, мэдээлэл, баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй.
  - 5.3.11. Андеррайтер үйлчилгээ үзүүлсэн бонд гаргагчийн бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавих үүрэгтэй бөгөөд бонд гаргагчийн тогтмол болон тухай бүр нийтэд мэдээлэл хүргэх үйлчилгээг үзүүлж болно.
  - 5.3.12. Бонд гаргагч нь бондын үүргийн гүйцэтгэлийн баталгаанд үл хөдлөх хөрөнгө барьцаалахаар шийдвэрлэсэн бол барьцаа хөрөнгийг эд хөрөнгийн бүртгэлийн төрийн эрх бүхий байгууллагад андеррайтер нь өөрийн нэр дээр барьцаалбарт бүртгүүлнэ.
  - 5.3.13. Андеррайтер нь бонд гаргагчийн хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн үүргийн тухай мэдээллийг Монголбанкны Зээлийн мэдээллийн санд нийлүүлж, шаардлагатай тухай бүрд мэдээллийг шинэчилнэ.
- 5.4. Арилжаа эрхлэх байгууллага дараах чиг үүрэгтэй
- 5.4.1. Арилжаа эрхлэх байгууллага нь нийтэд санал болгох бондыг өөрийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг өөрийн баталсан бүртгэлийн журмаар зохицуулна.
  - 5.4.2. Арилжаа эрхлэх байгууллага бүртгэлийн нарийвчилсан шаардлага, шалгуурыг хууль, энэ журамд нийцүүлэн дараах байдлаар тогтооно.
    - 5.4.2.1. нийтэд санал болгон анх удаа гаргах, нээлттэй болон хаалттай хүрээнд нэмж гаргах бондын танилцуулгын агуулгыг холбогдох хуульд нийцүүлэн энэ журмын 3.12-т заасан өөрчлөлтийг хийхэд тохиромжтой байдлаар тогтоох;
    - 5.4.2.2. бонд гаргагчийн үйл ажиллагааны онцлог, салбар, цар хүрээ зэрэг болон бусад хүчин зүйлтэй уялдуулан өөрийн хөрөнгийн зохистой харьцааны түвшинг ангилалтайгаар тогтоох;
    - 5.4.2.3. үнэт цаас нь тухайн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй этгээдийн нийтэд санал болгон гаргах бондын бүртгэлд хөнгөвчилсөн шалгуур тогтоох.

- 5.4.3. Арилжаа эрхлэх байгууллага нь бүртгэлийн шаардлага, шалгуур, бондын танилцуулгын бүрдэл нь журмын шаардлагыг хангаагүй, тооцоолол, судалгаа нь зөрүүтэй, бодит байдалд нийцээгүй тохиолдолд тухайн бондыг бүртгэхээс татгалзана.
  - 5.4.4. Бонд гаргагч нь тусгай зөвшөөрөл эзэмшдэг, хөрөнгийн зохистой харьцааны шалгуур хангах шаардлагатай үйл ажиллагаа явуулдаг бол тухайн этгээд бонд гаргахад ‘татгалзах зүйлгүй’ тухай тодорхойлолтын арилжаа эрхлэх байгууллага зохих эрх бүхий байгууллагаас авна.
  - 5.4.5. Арилжаа эрхлэх байгууллага бүртгэлийн шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг хянаж, тухайн бонд гаргагч болон түүний гаргах бонд нь зохих шалгуурыг хангасан бол бондыг бүртгэх эсэх асуудлыг хамтын шийдвэрийн зарчмаар шийдвэрлэнэ.
  - 5.4.6. Арилжаа эрхлэх байгууллага энэ журмын 5.4.5-д заасан хяналтын ажиллагааг ажлын 14 өдрийн дотор гүйцэтгэнэ.
  - 5.4.7. Арилжаа эрхлэх байгууллага бондыг бүртгэсэн тохиолдолд гаргасан шийдвэрийг дүгнэлт /Хавсралт 6-д заасан Маягт\*\*\*\*-ын дагуу/, ‘Бүртгэв’ тэмдэглэл бүхий бонд гаргагчийн ирүүлсэн танилцуулга /арилжаа эрхлэх байгууллагад хадгалагдах хувь/, бусад баримт бичгийн хуулбарын хамт ажлын хоёр өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.
  - 5.4.8. Арилжаа эрхлэх байгууллага нь анхдагч зах зээлийн арилжаа буюу андеррайтерийн захиалга авах үйл ажиллагаа нь үнэт цаасны танилцуулгад заасан журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих бөгөөд энэ тухай дүгнэлт гаргана.
  - 5.4.9. Арилжаа эрхлэх байгууллага Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэнд шинээр бүртгүүлсэн бондын хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.
  - 5.4.10. Бонд гаргагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, бүртгэлийн шаардлагыг хангахгүй болсон тохиолдолд тухайн бондыг арилжаа эрхлэх байгууллага өөрийн бүртгэлээс хасах эрхтэй.
  - 5.4.11. Бүртгэлтэй байгаа бонд энэ журмын 5.4.10-д заасан үндэслэлээр бүртгэлээс хасагдсан нь тухайн бонд гаргагчийн бүртгэлтэй бусад үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасах үндэслэл болно.
  - 5.4.12. Арилжаа эрхлэх байгууллага бонд гаргагчаас аливаа нэмэлт мэдээлэл, тодруулга, баримт бичиг ирүүлэх хүсэлт, эсхүл үндэслэл бүхий татгалзсан шийдвэрийг албан бичгээр хүргүүлэх бөгөөд ийнхүү хүргүүлэх тухай бүрд уг албан бичгийн хувийг Хороонд хүргүүлнэ.
  - 5.4.13. Арилжаа эрхлэх байгууллага үнэт цаасыг энэ журмын 5.4.10, 5.4.11-д заасан болон бонд гаргагчийн хүсэлтээр бүртгэлээс хассан бол уг шийдвэрийг мэдэгдэл /Хавсралт 7-д заасан Маягт \*\*\*\*-ын дагуу/-ийн хамт ажлын хоёр өдөрт багтаан Хороонд хүргүүлнэ.
- 5.5. Хороо дараах чиг үүрэг
- 5.5.1. Хороо нийтэд санал болгон гаргах бондыг бүртгэх, бүртгэлээс хасах шийдвэрийг арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрийг үндэслэн бүртгэнэ.
  - 5.5.2. Нийтэд санал болгон гаргасан үнэт цаас нь Хороонд бүртгэлтэй байгаа этгээдийн хаалттай хүрээнд буюу биржийн бус зах зээлд нэмж гаргах бондыг Хороо тухайн зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн бүртгэлийг үндэслэн бүртгэнэ.

- 5.5.3. Энэ журмын 3.1-д заасан бондын анхдагч зах зээлийн арилжааны захиалга авах зөвшөөрлийг Хорооны дарга, хоёрдогч зах зээлд арилжаалах зөвшөөрлийг Хорооны Ажлын албаны дарга тус тус олгоно.
- 5.5.4. Биржийн бус зах зээлд буюу мэргэжлийн хөрөнгө оруулагчдад, хаалттай хүрээнд санал болгох энэ журмын 3.2-т зааснаас бусад бондыг бүртгэхтэй холбоотой аливаа шийдвэрийг Хороо гаргахгүй.
- 5.5.5. Энэ журмын 5.1.11-д заасны дагуу бонд гаргагчаас Хороонд гомдол гаргасан тохиолдолд Хороо нь арилжаа эрхлэгч байгууллагын шийдвэрийг үндэслэлтэй эсэхийг хянах бөгөөд холбогдох этгээдээс уг асуудалтай холбоотой нэмэлт тайлбар, мэдээллийг шаардаж болно.
- 5.5.6. Бонд гаргагч энэ журмын 3.1-д заасан бондыг аливаа шалтгааны улмаас журмын 4.1-д заасан хугацаанд анхдагч зах зээлд гаргаагүй, эсхүл журмын 5.1.9-д заасан хугацаанд Хороонд мэдэгдэл хүргүүлээгүй тохиолдолд тухайн бондын нийтэд санал болгохыг зөвшөөрсөн бүртгэлийг хүчингүй болгоно.
- 5.5.7. Бонд гаргагч хүүгийн болон үндсэн төлбөрөө төлөөгүй, төлбөрийн чадваргүй болсон тохиолдол Хороо үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

### **ЗУРГАА. БОНД ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

- 6.1. Нээлттэй бонд гаргагч нь өөрөө, эсхүл андеррайтертай байгуулсан гэрээний үндсэнд энэ журамд заасан мэдээллийг тухайн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш бүртгэлээс хасах хүртэлх хугацааны туршид тогтоосон хэлбэр, давтамжаар Хороо, арилжаа эрхлэх байгууллага болон олон нийтэд Монгол хэлээр, шаардлагатай бол гадаад хэлээр давхар мэдээлэх үүрэгтэй.
- 6.2. Бонд гаргагч нь компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар хүргүүлнэ.
- 6.3. Нийтэд мэдээлэх арга, хэлбэрийг бондын танилцуулгад тусгах бөгөөд андеррайтертай байгуулсан гэрээнд нэмэлтээр тусгаж болно.
- 6.4. Энэ журмын 6.1-д заасан этгээдийн батлан даагч нь энэ журамд заасны дагуу зохих мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.
- 6.5. Энэ журмын 6.1-д заасан этгээдийн хувьцаа нь арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй бол Хороо болон тухайн арилжаа эрхлэх байгууллагын холбогдох журамд заасан мэдээллийн ил тод байдалтай холбогдох журмыг мөн дагаж мөрдөнө.
- 6.6. Энэ журмын 6.1, 6.4-д заасан этгээд нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг Хавсралт 8-д заасан маягтын дагуу Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, нийтэд мэдээлнэ.
- 6.6.1. Улирлын тайлан /Маягт БГ-У-ын дагуу/-г дараа сарын 10-ны өдрийн дотор;
- 6.6.2. Хагас жилийн тайлан /Маягт БГ-ХЖ-ын дагуу/-г дараа сарын 20-ны өдрийн дотор /эхний хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргах/;
- 6.6.3. Жилийн тайлан /Маягт БГ-Ж-ын дагуу/-г дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор /хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг тусгах, жилийн санхүүгийн тайланг хавсаргах/.

- 6.6.4. жилийн санхүүгийн тайланг Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулан дараа оны 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор;
- 6.7. Энэ журмын 6.1, 6.4-д заасан этгээд нь дараах тохиолдолд зохих мэдээллийг Хавсралт 9-д заасан маягтын дагуу Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, нийтэд тухай бүрд мэдээлнэ.
  - 6.7.1. бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны чиглэл, төсөл болон төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орсон бол тухайн үйл явдал болсноос хойш ажлын гурван өдрийн дотор;
  - 6.7.2. Бонд гаргагч бонд гаргах шийдвэрт заасны дагуу өрийн гаргасан бондыг төлөгдөх хугацаанаас өмнө эргүүлэн худалдан авсан бол энэ тухай мэдэгдэл /Маягт \*\*\*\*\*/-ийг тухайн арилжааны хэлцэл хийж эхэлснээс хойш ажлын гурван өдрийн дотор;
  - 6.7.3. Бонд гаргагчийн бусад санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчаас авсан зээл болон тэдний өмнө хүлээсэн нэмэлт мөнгөн төлбөрийн үүрэг үүссэн тухай мэдээллийг тухайн үйл явдал болсноос хойш ажлын гурван өдрийн дотор;
  - 6.7.4. удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон;
  - 6.7.5. хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт орсон;
  - 6.7.6. бонд гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан;
  - 6.7.7. бонд гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;
  - 6.7.8. бонд гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан;
  - 6.7.9. бондын үнэ, ханшид нөлөөлж болох бусад.

#### **ДОЛОО. ХАРИУЦЛАГА**

- 7.1. Бонд гаргагч нь энэ журмаар тогтоосон хугацаанд мэдээллийг холбогдох маягтаар хүргүүлээгүй, худал хуурмаг, төөрөгдүүлсэн шинжтэйгээр мэдээлсэн гэж үзвэл түүнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг үндэслэн Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх үндэслэл болно.
- 7.2. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 7.3. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

- Хавсралт 1* Нийтэд санал болгон гаргах бондыг бүртгүүлэх тухай өргөдөл
- Хавсралт 2* Хаалттай хүрээнд гаргах бондыг бүртгүүлэх тухай өргөдөл <sup>1</sup>
- Хавсралт 3* Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээдийн гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлэх бондын тухай мэдэгдэл
- Хавсралт 3* Санхүүгийн зохицуулах хорооны гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлэх бондын тухай мэдэгдэл
- Маягт \*\*\*\*\* - Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл  
Маягт \*\*\*\*\* - Санхүүгийн зохицуулах хорооны мэдэгдэл
- Хавсралт 4* Бондын анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлэх хүсэлт
- Хавсралт 5* Бондын анхдагч зах зээлийн захиалгын тайлан
- Хавсралт 6* Арилжаанд оруулахыг зөвшөөрсөн бондыг бүртгэсэн тухай дүгнэлт /Арилжаа эрхлэх байгууллага/
- Хавсралт 7* Арилжаанд оруулахыг зөвшөөрсөн бондыг бүртгэлээс хассан тухай дүгнэлт /Арилжаа эрхлэх байгууллага/
- Хавсралт 8* Бонд гаргагчийн тогтмол хүргүүлэх мэдээлэл
- Маягт \*\*\*\*\* - Улирлын тайлан  
Маягт \*\*\*\*\* - Хагас жилийн тайлан  
Маягт \*\*\*\*\* - Жилийн тайлан
- Хавсралт 9* Бонд гаргагчийн олон нийтэд зориулсан мэдээлэл
- Маягт \*\*\*\*\* - Олон нийтэд зориулсан мэдээлэл  
Маягт \*\*\*\*\* - Эргүүлэн худалдан авсан бондын мэдээлэл
- Хавсралт 10* Санхүүгийн зохицуулах хорооны ‘Бондын бүртгэлийн Маягт’

---

<sup>1</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.3, 9.4-т заасан этгээд /Журмын 3.2 дэх хэсэг/

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны \*\* дугаар сарын \*\*\*-ны өдрийн ..... дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын Хавсралт 1

Маягт: СЗХ \*\*\*\*\*

НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ  
БОНДЫГ БҮРТГҮҮЛЭХ  
ӨРГӨДӨЛ

Огноо: ...../...../.....  
(0000,сс,өө)

Дугаар: .....

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

**1. Бонд гаргагчийн мэдээлэл**

1.1. Нэр:

1.2. Хуулийн этгээдийн хэлбэр

Хувьцаат компани

ISIN код:

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1.3. Хөрөнгө оруулалтын хэлбэр

Дотоодын хөрөнгө оруулалттай

Гадаадын хөрөнгө оруулалттай

1.4. Үүсгэн байгуулагдсан огноо:

1.5. Улсын бүртгэлийн дугаар:

1.6. Регистрийн дугаар:

1.7. Үйл ажиллагааны чиглэл:

/чиглэл тус бүрийг бичнэ/

1.8. Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцоогч эсэх?

Тийм

Үгүй

Товч мэдээлэл:

1.9. Эзэмшдэг тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн дугаар, хугацаа, олгосон эрх бүхий байгууллага, эзэмшсэн огноо:

1.10. Өөрийн хөрөнгийн хэмжээ /тоо болон үсгээр/:

1.11. Хаяг:

1.12. Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл /5 буюу түүнээс дээш хувь эзэмшигч/:

Иргэн	Хуулийн этгээд
Овог, нэр:	Нэр:
Иргэний харьяалал:	Бүртгэлтэй улс:
Регистр /наспорт/-ийн дугаар:	Регистрийн дугаар:
Эзэмшиж буй хувь:	Эзэмшиж буй хувь:
	Үйл ажиллагааны чиглэл:
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:
Холбоо барих утас:	Холбоо барих утас, хаяг:
Эцсийн өмчлөгч:	Эцсийн өмчлөгч:

**2. Бондын мэдээлэл**

- 2.1. *Бонд гаргах хөрөнгийн бирж, бүртгүүлсэн огноо, шийдвэрийн дугаар*
- 2.2. *Бондын нэр:*
- 2.3. *Тоо ширхэг:*
- 2.4. *Нэрлэсэн үнэ:*
- 2.5. *Хугацаа:*
- 2.6. *Хүүгийн дээд/доод түвшин /жилийн/, төрөл /тогтмол, хөвөгч г.м/:*
- 2.7. *Хүү төлөх давтамж, үндсэн төлбөр төлөх хугацаа:*
- 2.8. *Бусад нөхцөл /хугацаанаас өмнө эргүүлэн худалдаж авах. хувьцаанд хөрвөх нөхцөлтэй г.м/*
- 2.9. *Нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон мөнгөн хөрөнгийн хэмжээ:*
- 2.10 *Тодорхой үе шаттай гаргах бол ерөнхий мэдээлэл:*
- 2.11 *Нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:*
- 2.12. *Бонд гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн зориулалтын талаарх товч мэдээлэл:*

Эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх

Хөрөнгө оруулалт

2.13. Барьцаа, баталгааны мэдээлэл:

2.14 Батлан даагчтай бол түүний мэдээлэл:

Нэр:

РД:

Өөрийн хөрөнгийн хэмжээ:

Батлан даалтын хэмжээ:

Хуулийн этгээд бол эцсийн өмчлөгч:

### 3. Бонд гаргагчийн андеррайтерийн мэдээлэл

3.1. Андеррайтерийн нэр<sup>2</sup>

3.2. Улсын бүртгэлийн дугаар:

3.3. Регистрийн дугаар:

3.4. Тусгай зөвшөөрлийн дугаар,  
огноо:

---

<sup>2</sup>Синдикат хэлбэрээр оролцож байгаа бол туслах андеррайтерийн мэдээллийг мөн бичнэ.

3.5. *Оршин байх албан ёсны хаяг:*

3.6. *Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:*

3.7. *Нийтэд санал болгон бонд гаргах үйл ажиллагаанд хүлээсэн үүргийн мэдээлэл:*

- Бондыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн худалдан авах*

*Дээд зэргийн хүчин чармайлт гаргах*

Баталгаажуулалт:

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны \*\* дугаар сарын \*\*\*-ны өдрийн ..... дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын Хавсралт 2

Маягт: СЗХ \*\*\*\*\*

ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ГАРГАХ  
БОНДЫГ БҮРТГҮҮЛЭХ  
ӨРГӨДӨЛ<sup>3</sup>

Огноо: ...../...../.....  
(0000,сс,өө)

Дугаар: .....

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

**1. Бонд гаргагчийн мэдээлэл**

1.1. Нэр:

1.2. Хуулийн этгээдийн хэлбэр

Хувьцаат компани  
ISIN код:  
 Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1.3. Хөрөнгө оруулалтын хэлбэр

Дотоодын хөрөнгө оруулалттай  
 Гадаадын хөрөнгө оруулалттай

1.4. Үүсгэн байгуулагдсан огноо:

1.5. Улсын бүртгэлийн дугаар:

1.6. Регистрийн дугаар:

<sup>3</sup> Энэхүү өргөдлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.3, 9.4-т заасан нийтэд санал болгон гаргасан үнэт цаас нь Хороонд бүртгэлтэй байгаа этгээд хаалттай хүрээнд буюу биржийн бус зах зээлд нэмж гаргах бондыг бүртгүүлэх хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд гаргахад бөглөнө. /Журмын 3.2 дэх хэсгийг харна уу./

1.7. Үйл ажиллагааны чиглэл:  
/чиглэл тус бүрийг бичнэ/

1.8. Компанийн тухай хуулийн 6.14-д  
заасан компанийн нэгдлийн  
оролцогч эсэх?

Тийм

Үгүй

Товч мэдээлэл:

1.9. Эзэмшдэг тусгай зөвшөөрөл,  
тусгай зөвшөөрлийн дугаар,  
хугацаа, олгосон эрх бүхий  
байгууллага, эзэмшсэн огноо:

1.10. Өөрийн хөрөнгийн хэмжээ /тоо  
болон үсгээр/:

1.11. Хаяг:

1.12. Бүртгэлтэй байгаа үнэт цаасны мэдээлэл<sup>4</sup>

Нэр, төрөл:

ISIN код:

СЗХ-нд бүртгүүлсэн огноо:

Нэрлэсэн үнэ:

Тоо, ширхэг:

Хугацаа:

Хүү:

Хүү төлөх давтамж:

Сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш:

Барьцаа, батлан даалттай эсэх:

<sup>4</sup> Бүртгэлтэй байгаа үнэт цаас тус бүрийн мэдээллийг бичнэ.

## 1.13. Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл /5 буюу түүнээс дээш хувь эзэмшигч/:

<i>Иргэн</i>	<i>Хуулийн этгээд</i>
<i>Овог, нэр:</i>	<i>Нэр:</i>
<i>Иргэний харьяалал:</i>	<i>Бүртгэлтэй улс:</i>
<i>Регистр /паспорт/-ийн дугаар:</i>	<i>Регистрийн дугаар:</i>
<i>Эзэмшиж буй хувь:</i>	<i>Эзэмшиж буй хувь:</i>
	<i>Үйл ажиллагааны чиглэл:</i>
	<i>Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:</i>
<i>Холбоо барих утас:</i>	<i>Холбоо барих утас, хаяг:</i>
<i>Эцсийн өмчлөгч:</i>	<i>Эцсийн өмчлөгч:</i>

**2. Бондын мэдээлэл**

2.1. Биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн шийдвэрийн огноо, дугаар:

2.2. Бондын нэр:

2.3. Тоо ширхэг:

2.4. Нэрлэсэн үнэ:

2.5. Хугацаа:

2.6. Хүүгийн дээд/доод түвшин /жилийн/, төрөл /тогтмол, хөвөгч г.м/:

2.7. Хүү төлөх давтамж, үндсэн төлбөр төлөх хугацаа:

2.8. Бусад нөхцөл /хугацаанаас өмнө эргүүлэн худалдаж авах. хувьцаанд хөрвөх нөхцөлтэй г.м/

2.9. Татан төвлөрүүлэхээр тооцсон мөнгөн хөрөнгийн хэмжээ:

2.10 Тодорхой үе шаттай гаргах бол ерөнхий мэдээлэл:

2.11 Хаалттай хүрээнд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:

2.12. Бонд гаргах замаар татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн зориулалтын талаарх товч мэдээлэл:

Эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх

Хөрөнгө оруулалт

2.13. Барьцаа, баталгааны мэдээлэл:

2.14 Батлан даагчтай бол түүний мэдээлэл:

<p>Нэр:</p> <p>РД:</p> <p>Өөрийн хөрөнгийн хэмжээ:</p> <p>Батлан даалтын хэмжээ:</p> <p>Хуулийн этгээд бол эцсийн өмчлөгч:</p>
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------

**3. Бонд гаргагчийн мэргэжлийн зуучлагчийн мэдээлэл**

3.1. Зуучлагчийн нэр<sup>5</sup>

3.2. Улсын бүртгэлийн дугаар:

3.3. Регистрийн дугаар:

3.4. Тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:

3.5. Оршин байх албан ёсны хаяг:

3.6. Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

3.7. Хаалттай хүрээнд бонд гаргах үйл ажиллагаанд хүлээсэн үүргийн мэдээлэл:

<p><input type="checkbox"/> Бондыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн худалдан авах</p> <p><input type="checkbox"/> Дээд зэргийн хүчин чармайлт гаргах</p>
----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Баталгаажуулалт:

<sup>5</sup>Синдикат хэлбэрээр оролцож байгаа бол бусад зуучлагчийн мэдээллийг мөн бичнэ.